

Дэлгэрэнгүй танилцуулга

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"

1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

1 дүгээр зүйл. Уг хууль нь 1 бүлэг 1 зүйлтэй.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай гэж тусгасан.

Энэхүү "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т зааснаар "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ" тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулахаар хүргүүлсэн /Хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав/.

Хавсралт

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн танилцуулга

Хөтөлбөрийн зорилго:

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр" нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвартай, нүүрсхүчлийн хийн ялгарал багатай, хүн ам амьдрахад таатай хот, суурин газар (аймаг, сумын төв)-ыг байгуулж, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх, орон нутгийн ногоон хөгжлийн загвар, шинэчлэлийг хөхиүлэн дэмжих, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зорилготой болно.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага:

Уг хөтөлбөр нь "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэх, "Ковид-19" цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэх, ногоон хөгжлийг дэмжих зорилтуудтай нийцсэн.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан чиглэлүүд болон хэрэгжүүлэх үйл ажиллагаатай нягт уялдаж байна. Тус хөтөлбөр нь хүнсний нийлүүлэлтийн сүлжээ, тогтолцоо, хүнсний аюулгүй байдлыг хангах, хот хөдөөгийн уялдаа холбоог дэмжих, аймаг, сумын төвүүдэд хүн амьдрахад таатай орчныг бүрдүүлэх, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох ногоон, хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх үндэс болох юм.

Үндсэн хэрэгжүүлэгч: Эдийн засаг, хөгжлийн яам.

Хамтран хэрэгжүүлэгч: Сангийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Хэрэгжих хугацаа: 2023 – 2033 он

Хөтөлбөр хэрэгжих байршил:

Энэхүү хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих инженерийн дэд бүтэц, тээвэр логистикийн төвийг байгуулах, хөдөө аж ахуйн салбарт оруулах ногоон санхүүжилтийг дэмжиж (тухайлбал: ногоон зээл, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл), хөдөө аж ахуйн менежментийг сайжруулан, түүнийг хянах тогтолцоог бүрдүүлнэ. Дээрх төлөвлөж буй арга хэмжээг 17 аймгийн 52 суманд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

№	Аймгийн нэр	Хамрах сумууд				Нийт
		1	2	3	4	
1	Архангай	Эрдэнэбулган	Эрдэнэ-мандал	Хотонт	Тариат	4
2	Булган	Булган	Хутаг-өндөр	Дашинчилэн	Хишиг-Өндөр	4
3	Дорнод	Хэрлэн	Халхгол	Баян-Уул	Дашбалбар	4
4	Сэлэнгэ	Сүхбаатар	Ерөө	Сайхан	Мандал	4
5	Төв	Зуунмод	Баянчандмань	Лүн	Угтаалтцайдам	4
6	Хэнтий	Хэрлэн	Батноров	Бор-Өндөр	Биндэр	4
7	Ховд	Жаргалант	Булган	Дарви	Манхан	4
8	Увс	Улаангом	Давст	Өмнөговь	Наранбулаг	4
9	Хөвсгөл	Мөрөн	Хатгал	Тариалан		3
10	Говь-Алтай	Есөнбулаг	Цогт	Баян-уул		3
11	Баян-Өлгий	Өлгий	Дэлүүн			2
12	Дундговь	Сайнцагаан	Эрдэнэдалай			2
13	Дархан-Уул	Дархан	Орхон			2
14	Өвөрхангай	Арвайхээр	Есөнзүйл			2
15	Баянхонгор	Баянхонгор	Бууцагаан			2
16	Завхан	Улиастай	Тосонцэнгэл			2
17	Дорноговь	Сайншанд	Замын-Үүд			2
Нийт	17 аймаг		52 сум			52

Хөтөлбөрийн I үе шатыг Ховд, Баян-Өлгий, Увс аймгууд болон хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийгдэх судалгаанд үндэслэн, бэлэн байдал хангасан 4 нэмэлт аймагт буюу нийт 7¹ аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Хөтөлбөр нь нийт 10 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн нийцсэн ба урт хугацааны бодлогын баримт бичгийн арга хэмжээг хэрэгжүүлэх суурь нөхцөл нь болно.

Төсөвт өртөг:

Хөтөлбөрийг Азийн хөгжлийн банк (АХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС) болон Европын хөрөнгө оруулалтын банк (ЕХОБ)-ны нэн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийт санхүүжилт 735.0 сая ам.доллар байх ба дараах эх үүсвэрүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Энгийн болон хөнгөлөлттэй зээл 550 сая ам.доллар;
- Буцалтгүй тусламж 78.0 сая ам.доллар;
- Засгийн газрын оролцоо² 75.3 сая ам.доллар;

¹ 2022 оны 10 дугаар сарын байдлаар Баян-Өлгий, Увс, Ховд аймгуудын төвд, Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумдад хийх ажлын ТЭЗҮ болон БОНҮ-г хийж гүйцэтгээд байна. 1 дүгээр үе шатны хүрээнд хэрэгжүүлэх бусад аймаг, сумдын ТЭЗҮ болон БОНҮ-г 1 дүгээр үе шатны санхүүжилтийн хүрээнд хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

² Бүтээн байгуулалтын үйл ажиллагаатай холбоотой НӨАТ, гаалийн татварын чөлөөлөлт, газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэлттэй холбоотой зардал гэх мэт.

- Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын ³ санхүүжилт 31.7 сая ам.доллар байна гэж тооцсон.

Хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны төслийн санхүүжилт 270.0 сая ам.доллар байх ба үүнээс:

- Энгийн болон хөнгөлөлттэй зээл 193.1 сая ам.доллар;
- Буцалтгүй тусламж 38.5 сая ам.доллар;
- Засгийн газрын оролцоо 20.7 сая ам.доллар;
- Хувийн хэвшил, банкны салбар болон бусад төсөлд оролцогч талуудын санхүүжилт 17.7 сая ам.доллар байна.

Санхүүжилтийн төлөвлөгөө:

(Үе шатаар, сая ам.доллар)

Эх үүсвэр	Үе шат (ҮСХ ⁴ ирүүлэх жил)			Нийт
	I үе шат 2023-2025	II үе шат 2026-2027	III үе шат 2028-2033	
А. Хөрөнгө оруулалтын төслийн бүрэлдэхүүн хэсэг				
Азийн хөгжлийн банк				
(i) Ердийн хөрөнгийн нөөц (энгийн эх үүсвэрийн зээл)	45.0	50.0	40.0	135.0
(ii) Ердийн хөрөнгийн нөөц (хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээл)	45.0	52.2	37.8	135.0
(iii) Тусгай сангийн нөөц (АХС - буцалтгүй тусламж)	3.0	0.0	0.0	3.0
2. Уур амьсгалын ногоон сан (зээл)	11.8	18.4	12.2	42.4
3. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж)	22.0	10.8	7.2	40.0
4. Европын хөрөнгө оруулалтын банк (зээл)	52.9	59.4	37.7	150.0
5. Европын хөрөнгө оруулалтын банк (буцалтгүй тусламж)	10.5	11.4	8.1	30.0
6. Монгол Улсын Засгийн газар*	20.7	33.5	21.1	75.3
7. Ашиг шим хүртэгчид**	3.4	2.0	1.3	6.7
Дэд нийлбэр (А)	214.3	237.7	165.4	617.4
В. Санхүүгийн зуучлалын зээл				
1. Уур амьсгалын ногоон сан (зээл)	38.4	29.6	19.6	87.6
2. Уур амьсгалын ногоон сан (буцалтгүй тусламж)	3.0	1.2	0.8	5.0
3. Арилжааны банкууд/Хувийн хэвшил	14.3	7.5	3.2	25.0
Дэд дүн (В)	55.7	38.3	23.6	117.6
Нийт (А + В)	270.0	276.0	189.0	735.0

АХБ, УАНС-ын зээлийн эх үүсвэрүүд нь дараах нөхцөлтэй. Үүнд:

- АХБ-ны хөнгөлөлттэй зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөж, жилийн тогтмол 2 хувийн хүүгийн түвшинтэй байна;

³ Төслийн хүрээнд үр шим хүртэх малчдын бүлэг, аж ахуй нэгж, олон нийтийн зүгээс хувь нэмэр оруулах хөдөлмөр, эд материал болон мөнгөн хөрөнгө оруулалтыг хамруулан тооцсон дүн.

⁴ Үечилсэн санхүүжилтийн хүсэлт

- АХБ-ны энгийн эх үүсвэрийн зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй. Хүүгийн түвшний хувьд Баталгаат овернайт санхүүжилтийн хөвөгч хүү⁵ дээр 0.5 хувийн нэмэгдэлтэй байх ба хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр⁶ 0.15 хувь байна;
- УАНС-гийн зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Хүүгийн түвшний хувьд 0.25 хувийн хүүтэй байх ба хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан төлбөр 0.5 хувь байна.
- Европын хөрөнгө оруулалтын банкны зээл: 25 жилийн эргэн төлөлтийн хугацаатай байх ба эхний 5 жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Хүүгийн түвшний хувьд тогтмол 2.92 хувийн хүүтэй бөгөөд хөрөнгө нөөцлөн баталгаажуулсан хураамж 0.15 хувь байна.

Мөн, Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийн "Олон шатлалт санхүүжилтийн хөтөлбөр" хэсэгт "Энэхүү Санхүүжилтийн ерөнхий хөтөлбөрийг байгуулснаар Монгол Улс нь санхүүжилт хүсэх хууль, эрх зүйн үүрэг хүлээх үндэслэл болохгүй. Монгол Улс нь Хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт хүсэхгүй байх эрхтэй. Түүнчлэн, Монгол Улс нь Хөтөлбөрийн хүрээнд хуваарилсан аливаа хөрөнгийг хэдийд ч буцаах эрхтэй." гэж заасан. Өөрөөр хэлбэл тус хөтөлбөрийг байгуулснаар хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эх үүсвэрийг олон улсын банк санхүүгийн байгууллагаас Монгол Улсад хуваарилж, түүнийг баталгаажуулж буй хэлбэр бөгөөд Монгол Улсын Засгийн газраас олон улсын байгууллагуудад тавих хүсэлтийн үндсэн дээр хуваарилсан эх үүсвэрийг ашиглана. Мөн уг хэлэлцээрт "СЕХ байгуулснаар АХБ нь аливаа санхүүжилт олгох хууль, эрх зүйн үүрэг хүлээх үндэслэл болохгүй. АХБ нь Монгол Улсын гаргасан санхүүжилтийн аливаа хүсэлтээс татгалзах, Хөтөлбөрийн ашиглагдаагүй хөрөнгийг цуцлах, Хөтөлбөрийн хүрээнд үе шатны санхүүжилт хүсэх Монгол Улсын эрхийг цуцлах эрхтэй ..." гэж заасан. Цаашид хөтөлбөрийн 1-3 дугаар үе шатны санхүүжилт тус бүрд тусгайлсан зээлийн хэлэлцээр болон буцалтгүй тусламжийн гэрээнүүдийг байгуулах замаар зөвхөн ашигласан зээлийн үлдэгдэлд үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүрэг хүлээнэ.

Хөтөлбөрийн хүрээнд хүрэх үр дүнгүүдийн санхүүжилтийн задаргаа:

(Бүрэлдэхүүн хэсгээр, сая ам.доллар)

Зүйл	Хөрөнгө оруулалт	Нийт	1 үе шат
Үр дүн 1: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгч бага ялгаруулдаг, хүн ам суурьших аймаг болон сумын төвүүдийг хөгжүүлэх	Дэд бүтэц: Агро-парк, дулаан, цахилгаан, авто зам, ус зайлуулах, хог хаягдлын байгууламж, дахин боловсруулах үйлдвэр	395.7	109.3
Үр дүн 2: Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, нүүрстөрөгчийн өндөр шингээлттэй, тогтвортой бэлчээр болон	Мал аж ахуйг дэмжих: • Өвчнөөс ангид 12 байгууламж, 6 аймаг болон 6 сум дундын түвшний	99.2	45.9

⁵ SOFR

⁶ Ашиглаагүй зээлийн үлдэгдэлд тооцогдох жилийн шимтгэлийн төлбөр

хөдөө аж ахуйн менежментийг хэрэгжүүлэх	<p>мал эмнэлгийн лабораториуд</p> <ul style="list-style-type: none"> Ус хураах, хэмнэх шийдлүүд бүхий 2500га малын тэжээлийн фермийн усалгаатай бүс Барилгын ажлын явцад 8000 хүнс-сарын ажлын байр болгоно 		
Үр дүн 3: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй малын болон агро-бизнесийн өртгийн сүлжээг бий болгох хүртээмжтэй санхүүжилт олгох	<p>Санхүүгийн зээл:</p> <ol style="list-style-type: none"> ЗГ-аар дамжуулан 50 сая \$-ын зээл, дамжуулан зээл, зээлийн эрсдэлийн батлан даалт Арилжааны банкуудаар 50 сая \$-ын зээл, дамжуулан зээл, зээлийн эрсдэлийн батлан даалт 	117.6	54.8
Үр дүн 4: Нүүрстөрөгч бага ялгаруулдаг, уур амьсгалд тэсвэртэй агро бүс нутгийн хөгжлийг хангах институцийн чадавх, бодлогыг бэхжүүлэх	<p>Зөвлөх үйлчилгээ ба сургалт:</p> <ul style="list-style-type: none"> 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургах уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн бизнесийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж бүсчилсэн хөгжлийн үндэсний 6 бодлогыг боловсруулж хэрэгжүүлсэн 	38.5	27.1
Нийт (А)		651.0	237.1
Төсөвлөгдөөгүй зардал (В)		59.3	24.0
Хэрэгжилтийн явц дах санхүүгийн төлбөр, хураамж (С)		24.7	8.9
Нийт (А+В+С)		735.0	270.0

Хөтөлбөрийн хүрээнд дараах тоон үзүүлэлтүүд хангагдахаар хүлээгдэж байна . Үүнд:

- Нийгмийн засаглал болон амьжиргааны түвшинг дэмжих: Хөтөлбөр нь ногоон эдийн засгийн өсөлт болон ажлын байр бий болгох асуудлыг дэмжиж, 11,400 ажлын байрыг шууд, 150,000 ажлын байрыг дам байдлаар бий болгоно.
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах: Хөтөлбөр хэрэгжих хугацаанд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах цэвэр дүн 117.4 сая тонн нүүрсхүчлийн хийн эквивалент (tCO₂e)-д байна. (Энэ нь Монгол Улсын үндэсний хэмжээнд хувь нэмэр оруулах 2030 оны зорилтын 70%-тай тэнцэж байна)
- Дасан зохицох үр өгөөж: Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох байдал болон байгаль орчны нөхцөл байдлыг сайжруулах үйл ажиллагааны шууд үр өгөөжийг хүртэгчид нь 552,300 хүн, үүний 54,000 орчим эмзэг бүлгийн малчин ерх, шууд бүс үр өгөөжийг хүртэгчид 3.2 сая хүн байна.
- Эко системийн нөхөн сэргээлт: Хөтөлбөр нь Монгол Улсын 28.8 сая га орчим бэлчээрийн тогтвортой, нүүрстөрөгч бага ялгаруулах менежментийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэ нь Монгол Улсын хөрсний доройтолд орсон нийт бэлчээрийн 1/3 болно.
- Хөдөө аж ахуйн аж үйлдвэрийн паркууд нь боловсруулах байгууламжуудыг хэрэгцээтэй цэгт бий болгож (улмаар боловсруулах хэлхээг богиносгож, мал аж ахуйн нийлүүлэлтийн сүлжээний нүүрстөрөгчийн агууламжийг бууруулж,

малчид, хүнсний үйлдвэрийн хооронд газарзүйн болон эдийн засгийн уялдаа холбоог сайжруулах замаар орон нутгийн эдийн засгийг дэмжих болно), хүнсний экспорт болон эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлнэ. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, ханган нийлүүлэлт болон логистикийн кластеруудыг ЭЗХЯ-наас эрэмбэлэн гаргана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Товч танилцуулга

"Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"

1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:

Уг хууль нь 1 бүлэг 1 зүйлтэй.

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт Монгол Улс, Азийн хөгжлийн банк хооронд 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай гэж тусгасан.

Энэхүү "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т зааснаар "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ" тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хурлаар батлуулахаар хүргүүлсэн /Хөтөлбөрийн дэлгэрэнгүй танилцуулгыг хавсаргав/.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

Уг хууль нь Монгол Улс, АХБ хооронд шинээр "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг байгуулж буй тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Сангийн яамны зүгээс Эдийн засаг, хөгжлийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам зэрэг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч яамдтай хамтран АХБ-тай тус хөтөлбөрийн зээлийн хэлэлцээрийг 2023 оны 1 дүгээр сарын 31-нээс 2 дугаар сарын 3-ны өдрүүдэд хийсэн.

4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.9 дүгээр зүйлд заасны дагуу олон улсын гэрээ соёрхон батлах тухай хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно гэж заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй болно.

5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:

Уг хуулийн хүрээнд зохицуулж буй Монгол Улс, АХБ хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкнаас хөтөлбөрийн гарын авлага болон АХБ-ны Ерөнхийлөгчийн зөвлөмж, дүгнэлт болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад судалгааг хийсэн.